



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 10 сарын 20 өдөр

Дугаар A/226

Улаанбаатар хот

**“Дүүргийн хүндэт тэмдэг”-ээр  
шагнах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.6 дахь заалт, Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны A/26 дугаар тогтоолоор батлагдсан “Онцгой амжилт гаргасан багш, сурагчдыг шагнаж урамшуулах журам”, 2025 оны A/07 дугаар тогтоолоор батлагдсан “Багахангай дүүргийн шагналын төрөл, түүнийг олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Итали улсад зохион байгуулагдсан Таеквондогийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээнээс Хүрэл медаль хүртсэн 91 дүгээр сургуулийн 9а ангийн сурагч Спортын дэд мастер Н.Цагаадай, дасгалжуулагч багш ОУХМ Б.Нэргүй нарыг “Дүүргийн хүндэт тэмдэг”-ээр шагнаж хүндэтгэл үзүүлсүгэй.

2. Арга хэмжээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталж, зарцуулагдах 1,490,000 (Нэг сая дөрвөн зуун ерэн мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2025 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн  
8/226 дугаар захирамжийн хавсралт



АРГА ХЭМЖЭЭНД ЗАРЦУУЛАГДАХ  
ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

| Д/д | Төсвийн нэр                            | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ  |
|-----|----------------------------------------|-------------|------------|----------------|-----------|
| 1.  | “Хүндэт тэмдэг” дагалдах мөнгөн шагнал | Ширхэг      | 1          | 500,000        | 500,000   |
|     |                                        |             | 1          | 300,000        | 300,000   |
| 2.  | Талархал                               | Ширхэг      | 2          | 95,000         | 190,000   |
| 3.  | Мөнгөн аяга                            | Ширхэг      | 1          | 500,000        | 500,000   |
|     | Нийт                                   |             |            |                | 1,490,000 |